

УЛС ТӨР

**Б.БАТБАЯР: ЗАСГИЙН ГАЗАР ХӨГЖЛИЙН
БАНКНААС САНХҮҮЖҮҮЛЭХ ТӨСЛИЙГ
ТУСГАЙЛАН ШИЙДВЭРЛЭХГҮЙ**

II нүүрт

ДЭЛХИЙ

БНСУ ЯПОНД БУУЛТ ХИЙХ НЬ

VI нүүрт



**АМ.ДОЛЛАРЫН ХАНШ
ӨСӨХ ҮҮ, БУУРАХ ҮҮ**

Н.ПҮНЦАГБОЛД

Валютын ханшийн зөрөөн дээр тоглолт хийж, ашиг олдог хүмүүс болоод нийт иргэдийн хамгийн их сонирхож байгаа асуулт энэ. Ам.долларын ханш өсөх үү, буурах уу. Сүүлийн үед ам.долларын ханш буурна, хадгалж хав дарж байгаа хүмүүс байвал зараарай. Төгрөгийн хадгаламжаа ам.доллар руу шилжүүлсэн бол одоо үнэтэй байгаа дээр нь зарж, ашиг ол гэх хүмүүс ч байна. Одоогоор бол ам.долларын ханш дунджаар 2500 төгрөгтэй тэнцэж байгаа. Арай ч ам.доллар 2500 төгрөгтэй тэнцэж, тэгтлээ ханш нь өснө гэж байхгүй хэмээн эдийн засагчид барин тавин ярьж байсан цаг саяхан. Гэтэл өнгөрсөн оны арваннэгдүгээр сард гэнэт савлаж, түүнээс хойш оллогтой буурч өгөхгүй байсаар 2500 төгрөгт тогтоод байна. Яахав, сүүлийн үед бол тогтвортой байгаа.

Үргэлжлэл нь III нүүрт

Дугаарын **60** мөр

ЧУХАЛ СЭДЭВ

“МАН БОГДЫНХОО БООРЦГИЙГ Л ТАРААНА”

Ж.ОТГОН

2017 оны онцлох үйл явдлын нэг бол Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль. Тэгвэл УИХ дахь олонхийн бүлэг оны анхны хуралдаанаараа Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийг хэлэлцэж, энэ сардаа багтан шинэчлэн батлахаар төлөвлөд хэлэлцэж эхлээд байгаа. Тэгвэл энэ асуудал нам эвслийн анхаарлыг татах болоод байна. Тухайлбал, зарим улстөрчид Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төсөл Үндсэн хуулийг зөрчиж

байна, Ерөнхийлөгчийн сонгуульд зөвхөн МАН-аас л хүн нэр дэвших эрхтэй болох нь, УИХ-ын гишүүд уншиж ч амжаагүй байтал ийм том хуулийг батлуулах нь маш аюултай гэх зэргээр байр сууриа илэрхийлсээр байгаа. Энэ хүрээнд УИХ дахь АН-ын бүлгийн хурлаар уг асуудлыг хэлэлцээд Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн талаар УИХ-д суудалгүй улс төрийн намуудын төлөөллийг хамруулж энэ долоо хоногт багтаан хэлэлцүүлэг зохион байгуулахаар шийдвэрлэсэн тухайгаа мэдэгдээд байгаа.

АН-ынхны мэдэгдэж буйгаар Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад өмнөх хуулиас 94 заалтыг өөрчилж, 100 орчим зарчмын зөрүүтэй саналыг оруулсан гэнэ. Энэ бүхнээс харж байхад МАН-ын бүлэг 65 кнопоор хүч түрэн, хэн нэгэнд зориулагдсан хууль мэндлэх гэж байж ч болзошгүй байдал үүсээд байгаа. Ямар ч байсан энэхүү хуулийн талаар УИХ-д суудалгүй улс төрийн намуудын төлөөлөл юу гэж харж байгаа талаар байр суурийг хүргэж байна.

Үргэлжлэл нь IV-V нүүрт

Хязгаарлалт хамгийн зөв шийдвэр байлаа

Э.ТУУЛ

Улаанбаатар утаандаа живж, уушгины хатгалгаа хэрээс хэтэрч, уур унтууг нь барж байгаа талаар амтай болгон ярилаа, ойрын өдрүүдэд. Жагсч цуглаж, шаардлага хүргүүлж, төрийн томчуудыг харааж зүхсээр олон хоногийг үдэв. Ингэж уурлаж бухимдсаны үр дүн эхнээсээ төрийн томчуудад хүрч, бас ч гэж тодорхой арга хэмжээнүүдийг авч эхэллээ. Энэ бол сайн хэрэг. Ямар ч байсан эхний ээлжинд цахилгаан, эрчим хүчний шөнийн тарифыг тэглэж, “Агаарын бохирдлыг бууруулахад иргэн таны оролцоо” технологийн үзэсгэлэнг гаргаж, халаагуур сонгох арга замыг нээж өглөө.

Үргэлжлэл нь III нүүрт

Улаанбаатар: ӨНӨӨДӨР



Өдөр -16
Шөнө -27

Улаанбаатарын агаарын бохирдол ДЭМБ-аас тогтоосон

АР 0 ӨӨ 0 АЭ 0 ҮИ 0 ҮҮИ ҮҮН 4 АА 0 ӨИ 0 ӨӨ ААЭИ А!!!



ХААН банк	Авах		Зарах		Хугалгаа хөгжлийн банк	Авах		Зарах	
	АМ.ДОЛЛАР	ЕВРО	ФУНТ	РУБЛЬ		АМ.ДОЛЛАР	ЕВРО	ФУНТ	РУБЛЬ
АМ.ДОЛЛАР	2494.00	2619.00	2505.00	2989.00	АМ.ДОЛЛАР	2493.00	2505.00	ФУНТ	2998.00
ЕВРО	2619.00	21.43	2686.00	39.90	ЕВРО	2617.00	2697.00	РУБЛЬ	40.31
ИЕН	21.43	21.75	21.75	358.50	ИЕН	21.36	22.02	ЮАНЬ	359.00
				3089.00					3087.00
				43.40					44.12
				364.40					364.90

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

БАЙНГЫН ХОРОО

Кубын Засгийн газар тэтгэлэг олгох тоог нэмэгдүүлнэ гэв

Куба Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Раул Дэлгадо Консепсионны хүлээн авч уулзлаа. Уулзалтын үеэр талууд боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарт хэрхэн харилцан ашигтай хамтран ажиллаж болох талаар санал солилцов. Уулзалтын эхэнд ноён Раул Дэлгадо Консепсион “Өнгөрсөн онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Куба Улсад хийсэн айлчлал нь хоёр орны хувьд 30 гаруй жилийн дараа дээд түвшинд болсон үйл явдал бөгөөд цаашдын хамтын ажиллагаанд чухал түлхэц үзүүлнэ гэдэгт итгэж байна. Боловсролын салбарын хамтын ажиллагаа манай хоёр орны хамтын ажиллагаанд чухал байр суурь эзэлдэг. 1994 оноос хойш нийт 140 гаруй оюутанд Кубын Засгийн газраас тэтгэлэг олгосон бөгөөд цаашид ч энэ тоог нэмэгдүүлэх болно” гэв. Мөн хоёр улсын кино өдрүүдийг харилцан зохион байгуулах, тус улсын спортын хүрээлэнгэй хамтрах зэрэг өргөн боломжийн талаар хэлэлцлээ. Түүнчлэн Куба улсад зохион байгуулагддаг кино фестивалд манай улсын уран бүтээлчдийг оролцуулах боломжтойг дурдлаа. Талууд хоёр орны спортын салбарт хамтран ажиллаж ирсэн туршлагатай дурдаж, тамирчдын бэлтгэлийг Куба Улсад хийх боломжтой гэв.

Ж.ОТГОН

УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцэх эсэхийг хэлэлцсэн юм. Хууль санаачлагчийн илтгэлийг УИХ-ын гишүүн Б.Жавхлан танилцуулав. Тэрбээр танилцуулгадаа “Монгол Улсын Хөгжлийн банк үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн улс орны эдийн засгийн хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж ирсэн боловч тус банкны үйл ажиллагаа болон холбогдох бусад харилцааг зохицуулсан хууль тогтоомжийг улам боловсронгуй болгох, банкны бие даасан байдлыг дээшлүүлэх, үр ашигтай ажиллах боломжийг нэмэгдүүлэх, шаардлага бий болж байна гэдгийг онцолж байлаа. Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах явцад Өмнөд Ази, Латин америк, Африк тивийн зарим орнууд дахь Хөгжлийн банкуудын эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийж үзжээ. Улс төрөөс хэт хараат байдал, банкны бие даасан, хараат бус байдал алдагдсан, үйл ажиллагаага нь улсынхаа санхүү, эдийн засгийн бодлоготой уялдаагүй, эдийн засгийн хувьд үр өгөөж багатай байв. Түүнчлэн нийгмийн төсөл, хөтөлбөрүүдийг хэт ихээр санхүүжүүлсэн, санхүүжилтийг хэт бага хүүгээр олгох нь урт хугацааны тогтвортой үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, хяналт, шинжилгээ үнэлгээний үйл ажиллагаа хангалтгүй зэрэг нийтлэг сул талууд ажиглагдсанаас гадна чанаргүй зээлийн хэмжээ нийт зээлийн багцын 50 хувьд хүрсэн тохиолдол ч гарсан байсан. Харин Зүүн Азийн орнуудын Хөгжлийн банкуудын амжилтын нууц нь тэдгээрийн үйл ажиллагаа нь улс төрөөс ангид байгаж, санхүүжүүлж буй төсөл бүрийг бодитойгоор үнэлэх, хянаж хөшүүрэг, механизмыг бий болгож, үйл ажиллагааны хүрээг өргөжүүлэн, хөгжилд зориулсан бусад төрлийн санхүүгийн хэрэгслүүдийг нэвтрүүлж чадсан байжээ” гэлээ. Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар уул уурхай, дэд бүтэц, аж үйлдвэр гэх мэт тэргүүдэл болон стратегийн ач холбогдол бүхий салбарууд, ялангуяа экспортыг дэмжих төслүүдийг шуурхай хэрэгжүүлэхэд түлхэц болох аж. Түүнчлэн цаашид эдийн засгийн өсөлтийг хангаж, ядуурлыг бууруулах, иргэдийн ажлын байраа хангаж, тогтмол орлогын эх үүсвэртэй болгоход чухал дэмжлэг болно гэж хууль санаачлагчид үзжээ. Түүнчлэн банк тогтвортой, үр ашигтай ажиллах, үйл ажиллагааны эрсдэл буурах, зээл олгох үйл ажиллагааны шуурхай байдал хангагдах, банкны үйл ажиллагааны хүрээ өргөжих, компанийн засаглал бэхжих гэнэ. Мөн банкны үйл ажиллагаанд тавих хяналтын тогтолцоо боловсронгуй болсноор олон



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

нийтийн банкинд итгэх итгэл өсч, цаашид банкны нэр хүнд, зээлжих зэрэглэл өсөх боломж нэмэгдэх зэрэг ач холбогдолтой гэж үзэж байгаа юм байна. Хэлэлцүүлгийн шатанд Хөгжлийн банкны захирал Б.Батбаяр “УИХ-аас Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, дунд хугацааны хөтөлбөрүүдийг баталсан. Энэ дагуу бид эдийн засгийн үр ашгийг тооцож, 60 гаруй хувь нь экспортыг дэмжихэд, 40 гаруй хувийг нь импортыг орлоход чиглэсэн төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлж, зээл олгоно. Өмнө нь Засгийн газартогтоол гарган батлаад төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх, зээл олгох асуудлыг чиглүүлдэг байсан. Харин шинэчилсэн найруулгад Засгийн газрын хөрөнгийг итгэмжлэн удирдахаас бусад тохиолдолд Засгийн газар Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийг тусгайлан шийдвэрлэхгүй байхаар тусгасан” гэлээ. Харин УИХ-ын гишүүн Б.Жавхлан “Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгын гол зангилаа нь банкны бие даасан байдлыг хангахад чиглэсэн байгаа. Гиймээс Засгийн газарт зээл олголт дээр хяналт тавихгүй. Хөгжлийн банк улс орны эдийн засгийг дэмжих бодлогод тулгуурлаж төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжилнэ” гэв. Мөн УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ “Хөгжлийн банкны үйл ажиллагаа Засгийн газрын нөлөөгөөр явж ирсэн өмнөх жишгийг хэрхэн арилгах гэж байна вэ гэдгийг тодруулсан юм. Үүний хариуд Хөгжлийн банкны тэргүүн дэд захирал Ч.Энхбат “УИХ-аас Монгол Улсын 2030 онд баримтлах Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг баталсан. Мөн Засгийн газрын ирэх дөрвөн жилийн үйл ажиллагааны хөтөлбөр болон дунд хугацааны хөтөлбөр зэрэг баримт бичигт туссан экспортыг дэмжиж, импортыг орлох үйлдвэрлэлийг Хөгжлийн банк санхүүжүүлнэ. Одоогийн хэрэгжиж байгаа хуулиар УИХ-ын хаврын чуулганаар баталсан төсөл хөтөлбөрийг Хөгжлийн банк санхүүжүүлнэ гэсэн заалттай боловч уг заалт огт хэрэгжээгүй. Үүний оронд

Засгийн газрын тогтоолоор төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлж ирсэн байдаг. Шинэ хуулиар эдийн засгийн үр ашигтай, тооцоо судалгаагаар хөтөлбөрийг санхүүжүүлэхээр тусгасан” гэв. Ийнхүү Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёолоор санал хураахад хуралдаанд оролцсон гишүүдийн 90 хувь нь дэмжсэн юм. Уг хуулийн төслийг хэлэлцсэн эсэх талаархи байнгын хорооны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Л.Элдэв-Очир УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар болов. Мөн уг шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэж, баглуулах үүрэг бүхий ажлын хэсгийг УИХ-ын гишүүн Л.Элдэв-Очир ахлахаар боллоо.

Авлига авсан бол эрүүгийн хариуцлага хүлээнэ гэв

УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар /Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд гишүүдийн 76.9 хувийн саналаар дэмжин, чуулганы нэгдсэн хуралдаанд оруулах нь зүйтэй хэмээн үзсэн юм. Засгийн газраас өргөн мэдүүлсэн энэхүү хуулийн төслийн 60 гаруй заалт нь албадан ажил хөдөлмөр эрхлүүлэхээр заасан бол авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ялыг чангаруулж, тэнсэн өгөхгүй байхаар зааж өгсөн юм. Хэлэлцүүлгийн үеэр УИХ-ын гишүүн Л.Мөнхбаатар “Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгыг буцаасан нь зөв байсан гэдгийг юуны түрүүнд хэлбэ. Өмнөх хуульд хорих ялын доод хэмжээ долоо хоног байсныг өөрчилж, одоогийн энэ төсөлд 6 сар болгооно гэж байна. Үйлдсэн гэмт хэрэгтэй нь холбоотойгоор нэг сар, хоёр сар хорих ялаар шийтгэж болохгүй юу” гэдгийг тодруулав. Харин Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт “2015 оны Эрүүгийн хуулийн бүх гэмт хэрэгт хорих ял шийтгэхээр болчихсон байсан. 440 заалт гэмт хэрэг 100 хувь хорих ялтай болчихсон. Бид хуульд заавал

хорихыг урьтал болгохгүй байх зарчмыг барьж, хөнгөн гэмт хэрэгт хорих ял оногдуулахгүй байхаар тусган, хорих ялын доод хэмжээ долоо хоног байсныг зургаан сар байхаар заасан. Гэмт хэрэг хийсэн гээд л 7 хоногийн ял өгөөд байж болохгүй шүү дээ. Хүний давж заалдах шатны шүүхэд хандах эрх зөрчигдөж байгаа, энэ тохиолдолд. Өөрөөр хэлбэл, гэм буруутгүй гэдгээ нотлох завдал өгөхгүйгээр шууд хорьчихож байгаа юм. Мөн алслагдсан аймагт хорих ялаар шийтгүүлсэн хүнийг аймаг, нийслэл рүү авч явах хороонд л ял эдлэх хугацаа нь дуусч байх жишээний. Энэ мэт байдлаас шалтгаалан хүн бүрт хорих ял оноох байсныг өөрчилсөн” гэлээ. Харин УИХ-ын гишүүн О.Баасанхүү “Авлига өгсөн хүнийг яллахгүй байх тухай их ярьдаг боллоо. Яахаараа авлига өгсөн хүн ялгүй байдаг юм бэ” гэв. Үүний хариуд Хууль зүй, дотоод эрхэгийн сайд С.Бямбацогт “2015 онд баталсан Эрүүгийн хуульд авлига өгсөн хүнд огт хариуцлага тооцохгүй байхаар заасан байсан. Бид үүнд зохицуулалт хийсэн. Тухайлбал, зориудаар, зохион байгуулалттайгаар авлига өгсөн бол хариуцлага хүлээнэ, бусдын дарамт шахалтад орж авлига өгөхөд хүрсэн бол хариуцлага хүлээхгүй байхаар шийдсэн. Харин авлига авсан бол ял ч тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээнэ” хэмээн тайлбарлав.

Согтуу иргэдийг цагдаагийн харьяанд эрүүлжүүлнэ

Үүний дараа Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцээд олонхи гишүүн дэмжсэнээр “Төслийг хэлэлцэх нь зүйтэй” хэмээн үзлээ. Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиар архи, согтууруулах ундаа хэрэглэн, өөрийгөө хянах чадваргүй болсон иргэнийг эмнэлэгт эрүүлжүүлж байгаа юм. Гэвч энэ нь эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа иргэдэд хүндрэл учруулж, эмч нарын

ажлын ачааллыг нэмэгдүүлж байгаа учраас 2014 онд баталсан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзэн, дээрх төслийг оруулж иржээ. Уг төсөл батлагдсан нөхцөлд согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн, өөрийгөө хянах чадваргүй болсон иргэнийг цагдаагийн байгууллагын харьяанд байх эрүүлжүүлэх байранд эрүүлжүүлэх юм. Ингэхдээ эрүүл мэндийн тусламжийг эмч үзүүлж байхаар зааж өгсөн. Мөн албадан эрүүлжүүлэх үйл ажиллагаа цагдаагийн байгууллагад шилжиж байгаатай холбогдуулан хүн амын нягтрал, согтуугаар үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийн байдлыг харгалзан тодорхой нутаг дэвсгэрт эрүүлжүүлэх байрыг байгуулах гэнэ. Эрүүлжүүлэх байранд төлбөртэй эрүүлжүүлнэ. Эрүүлжүүлэх байрны нөхцөл, эмчилгээ, үйлчилгээний журмыг эрүүл мэндийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд, үйлчилгээний төлбөрийг хууль зүйн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батлахаар хуулийн төсөлд тусгажээ.

Казиногийн хуулиар Ажлын хэсэг байгууллаа

УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар, Казино байгуулах тухай хуулийн төслөөр Ажлын хэсэг байгуулахаар боллоо. Ажлын хэсгийг УИХ-ын гишүүн Л.Энхболд ахалж, Н.Учрал нарын гишүүдийг багтаахаар болсон юм. Өмнөх парламентын үед Засгийн газраас Казино байгуулах тухай хуулийн төслийг өргөн мэдүүлсэн бөгөөд хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж байжээ. Тиймээс энэ УИХ-ын Хууль зүйн байнгын хорооноос ажлын хэсэг байгуулж буй аж. Казино байгуулах тухай хуулийн төслийг УИХ-д 2015 оны хоёрдугаар сард өргөн мэдүүлсэн. Түүнд тусгаснаар хоёр ч казино байгуулахаар заасан. Казиногоор зөвхөн гадаадын иргэд үйлчлүүлэх эрхтэй байхаар томьёолсон. Казино байгуулсан нөхцөлд жилд улсын төсөвт 74-130 тэрбум төгрөг төвлөрөх тооцоог тухайн үед гаргасан байв.

МОНГОЛЫН МЭДЭЭ

19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч: Ч.ЧУЛУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 90873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчлаланы алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн Н.ПУНЦАГБОЛД

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/, 2 давхар, 209, 211 тоот

Харилцах утас, факс: 976-70113551

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэл үйлдвэрт хэвлэв.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийг энэ сараас дагаж мөрдөх нь

УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж, ажлын хэсгээс оруулж ирсэн зарчмын зөрүүтэй 70 гаруй саналаар санал хураалгалаа. Тухайлбал, уг хуулийг дагаж мөрдөх хугацааг энэ оны нэгдүгээр сарын 16-нарс байхаар санал орж ирсэн нь дэмжлэг хүлээлээ. Учир нь, сонгуулийн товыг 150 хоногийн өмнө зарлана, сонгуулийн санал хураалтыг зургадугаар сарын сүүлийн долоо хоногт зарлана гэх хоног хугацаатай

заалтуудтай холбоотой аж. Энэ асуудалтай холбогдуулж Сонгуулийн ерөнхий хорооны дарга Ч.Содномцэрэн “Сонгуулийн бэлтгэл ажлыг хангахтай холбоотойгоор Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийг нэгдүгээр сарын 16-наас дагаж мөрдөхөөр тусгавал сайн байна” гэсэн юм. Хуулийн төсөлд туссан энэ заалттай холбоотойгоор УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд “УИХ дахь Ардчилсан намын бүлэг энэхүү хуулийн төслөөр завсарлага авчигүй бол батлагдах боломжтой” гэдгийг тодотгосон юм.

Сонгуулийн хуулийн маргааныг хэлэлцэнэ

Сонгуулийн тухай хуулийн санал тоолох, саналын хуудас, санал хураалтыг хүчингүйд тооцохтой холбоотой зарим зүйл иргэний сонгох болон сонгогдох, шүүхэд хандах эрхийг хязгаарлаж Үндсэн хуулийн холбогдох

гэсэн мэдээлэл, гомдлыг нэр бүхий иргэд Үндсэн хуулийн Цэцэд ирүүлжээ. Уг мэдээлэл, гомдлоор үүссэн маргааныг хянан хэлэлцэх Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаан энэ сарын 18-ны өдөр болох юм байна.

Ерөнхийлөгч олон нийтэд хандаж мэдээлэл хийнэ

Төрийн ордонд Үндэсний аюулгүй байдлын зөвлөл нийслэлийн агаарын бохирдлын асуудлаар өргөтгөсөн хуралдаан хийсэн. Эл хуралдааны талаар Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж цахим хуудаснаа “Өнөөдөр Нийслэлийн агаар, орчны бохирдлын асуудлаар Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн өргөтгөсөн хурал хийлээ. Хэлэлцэж тохирсон асуудлаар ҮАБЗ-ийн шийдвэр-Зөвлөмж

гарав. Зөвлөмжийг хэрэгжүүлж хамтран ажиллах нь нийт иргэд, байгууллагын журамт үүрэг болж байна. Эндээс бүрэн эхээр нь татаж танилцана уу” хэмээжээ. Тэгвэл Ерөнхийлөгч ҮАБЗ-ийн хурлаар хэлэлцсэн нийслэлийн агаарын бохирдол, утааны асуудлаар өнөөдөр Төрийн ордны Иргэний танхимд 10.00 цагаас олон нийт, хэвлэл мэдээллийг хандаж мэдээлэл хийхээр болжээ.

ҮЗЭЛ БОДОЛ

Дугаарын **60** мөр

Хязгаарлалт хамгийн зөв шийдвэр байлаа

Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт

Түүгээр ч барахгүй Улаанбаатар хотын Захирагч Су.Батболд хэд хэдэн захирамж гаргаж, утааны эсрэг арга хэмжээ авч эхэллээ. Байнга баалуулж, түмний уурыг хүргээд байсан Хотын дарга маань нэг удаа ч гэсэн чихэнд чимэгтэй мэдээ дуулгасанд баярлаад байх юм. Хотын даргын захирамжид Улаанбаатарт суурьшлын бүс тогтоох буюу улаан шугам татаж, шугам татсан буюу суурьшлын бүсийн тогтоосон хэсгээс гаднах хэсэгт шинээр гэр хороолол төлөвлөж, шинэ суурьшлын бүсийг бий болгохгүй байхаар захирамжиллаа. Мөн агаарын чанарын өнөөгийн байдлыг харгалзан нийслэлд агаарын бохирдлын дөрвөн бүсчлэлийг тогтоож, нэгдүгээр бүс буюу орон сууц, байшин хороололд ямар ч тохиолдолд яндангаас утаа гаргах ёсгүй. Харин 2-4 дүгээр бүсэд тодорхой заагтайгаар аль хэсэгт нь цахилгаан халаагуур, аль хэсэгт нь сайжруулсан түлш хэрэглэх вэ гэдэг асуудлыг захирамжилж өгч. Хамгийн сэтгэлд нийцсэн захирамж нь “Хязгаарлалтын арга хэмжээ авах тухай” юм. Энэхүү захирамжаар шилжилт хөдөлгөөнийг хязгаарлаж, Улаанбаатар хотод зөвхөн зайлшгүй шаардлагаар удаан хугацаанд эмчлүүлэх шаардлагатай хүмүүсийг л шилжиж ирүүлнэ. Мөн Улаанбаатар хотод зээлд хамрагдан орон сууц худалдаж авсан иргэнийг шилжилт хөдөлгөөнийг зөвшөөрнө. Бусад тохиолдолд 2018 оны нэгдүгээр сарын I-ний өдөр хүртэл шилжилт хөдөлгөөнийг хориглож байгаа юм. Энэ бол ёстой зөв шийдвэр. Энэ шийдвэрийг гаргасны дараа хүмүүс “Үндсэн хуулиас давсан захирамжийг Хотын дарга гаргалаа” гэх зэргээр шүүмжилж байна.

Үнэндээ насаар нь хорьж, хязгаарлах гэж байгаа ч биш хэдхэн жил хязгаарлахад яагаад болохгүй гэж. Дээрээс нь энэ их утааг гаргаж байгаа хүмүүс нь гэр хорооллынхон гэж ад үздэг хүн бишгүй олон бий. Мөн хөдөөнөөс орж ирсэн “оркууд” л замын хөдөлгөөнд соёлтой оролцдоггүй, нус цэрээ ил задгай хаядаг, шээж баадаг, ядаж гарцаар гардаггүй гээд л амаа олохгүй муулдаг. Ялангуяа их, дээд сургуулийн хичээлийн шинэ жил эхлэх үеэр буюу орон нутгаас оюутан болоод ирэх үеэр ингэж ярих нь их бий. Түүгээр ч барахгүй тэднийг хотын соёлд сургаа гэх мэтээр шүүмжилдэг. Тэгвэл энэ асуудлыг чинь шийдэхийн тулд, хоёр жилийн хугацаатай хориг тавьчихлаа. Яадаг юм. Энэ хугацаанд ачааллаа дийлэхээ больсон гэр хороолол чинь тэлэхгүй байх нь. Дээрээс нь хоёр жилийн хугацаанд дахин төлөвлөлтийн ажил үргэлжлээд орон сууцаа олигтойхон бариад, ипотекийн зээлээ хөнгөлөлттэй нөхцлөөр олгоод эхэлбэл асуудал нэлээд шийдэгдэх байх. Хотын даргын захирамж цагаа олсон шийдвэр гэдгийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл ч дэмжчихлээ. Өчигдөр Үндэсний аюулгүй байдлын зөвлөл агаарын бохирдлын асуудлаар Төрийн ордонд өргөтгөсөн хуралдаан хийж, Хотын даргын гаргасан захирамжийг хэлэлцээд, шийдвэрийг нь дэмжиж зөвлөмж гаргахаар боллоо. Одоо хэрэгжилтэд нь хатуухан хяналт тавих хэрэгтэй шүү.

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ



УИХ-ын гишүүн У. Намдорж

ҮЗЭЛ БОДОЛ

АМ.ДОЛЛАРЫН ХАНШ ӨСӨХ ҮҮ, БУУРАХ УУ

Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт

Гэхдээ 2000 төгрөг дөнгөж давж байхад сүр болж байсан бид даруй 500 төгрөгөөр нэмэгдээд хэсэг тогтворжиход санаа амарч байх жишээтэй. Санаа амрахгүй гээд ч яах билээ, үүнээс ч илүү өсөх ч байсан юм бил үү. Харин ойрдоо буурах шинж байгаа бил үү. Байж болно оо. ОУВС-гийн зээл удахгүй бүтэж магадгүй байгаа. Ерөнхийдөө нааштай хандлага гарч эхэлсэн. Энэ сарын 20-нор ОУВС-гийн баг манайд ирэх сураг байсан. Бодвол эцсийн байдлаар асуудлаа шийдэх гэж байгаа юм байлгүй дээ. Ерөнхийдөө зээл цагаан сарын хавьд бүтэх бололтой. 450 сая ам.долларын зээл. Хэрвээ энэ хэмжээний зээл ороод ирвэл мэдээж ам.долларын ханшинд нөлөөлнө. Тиймээс 2500 төгрөгөөс арай буурч, 2300 руу орох болов уу. Хэдий хэмжээний ам.доллар орж ирэхээс шалтгаалж ханш буураах асуудал яригдана. Өмнө нь 2009 оны Стэнд бай хөтөлбөрийг хэрэгжүүлэх үед 2048 төгрөгт хүрч байсан ам.долларын ханш хоёрхон сарын дотор 1428 төгрөг болтлоо буурч байжээ. Энэ удаад ч гэсэн гэр түүх давтагдаж магадгүй юм. Тийм болохоор 2500 төгрөг байгаа дээр нь бушуухан зарах нь зүйтэй. Ер нь ОУВС-гийн зээл ороод ирвэл гуравдугаар сарын эхээр ам.доллар 2300 орно гэсэн хүлээлт бий болсон. Нэг ам.доллар тутмаас 200 төгрөг алдана гэвэл

нэлээд алдагдал хүлээх нь тодорхой. Тиймээс ашиг олох л гэж байгаа бол одоо бушуухан зарах нь хамгийн зөв шийдэл юм. Гэхдээ зөвхөн нэг талаас нь харж үзвэл ийм байна.

Ам.долларын ханш цагаан сар хүртэл өснө

Одоо нөгөө талаас нь хараад үзье. ОУВС-гийн зээл цагаан сарын үеэр биш гуравдугаар сарын дундуур орж ирнэ гэсэн мэдээлэл ч бас гарч ирээд сураг байсан. 450 сая ам.долларын зээл шүү дээ. Энэ зээл ямар ч байсан бүтэх нь бүтнэ. Харин хугацаа нь жаахан хойшилж магадгүй байгаа юм. Өөрөөр хэлбэл, Хөгжлийн банкны 580 сая ам.долларын бондын эргэн төлөлт хийгдэх үеэр орж ирнэ гэх мэдээлэл гарч байна. Хэрвээ тэгвэл энэ мөнгөөр

бид өрөө төлөөд л таарах нь. Манайд валют орж ирээд, ханшинд нөлөөлөхгүй гэсэн үг. Хэрвээ тэгвэл ам.долларын ханш улам өснө. Харин зарим эдийн засагчдын таамаглаж байгаагаар арай ч ОУВС-гийн зээлийг Хөгжлийн банкны 580 саяын бондын дарахад зарцуулахгүй байх. Харин шинээр долоо хувийн хүүтэй таван жилийн хугацаатай бонд гаргаж, төлөх болов уу гэсэн таамаг гарсан. Ингэсэн тохиолдолд байдал арай өөрөөр эргэнэ. Гэвч хамгийн гол нь ОУВС-гийн зээл гуравдугаар сараас нааш орж ирэхгүй бол ам.долларын ханш ойрдоо

буурна гэж найдаад хэрэггүй. Ямар ч байсан цагаан сар хүртэл зүтгүүлж байгаад ам.долларын ханш дахиад жаахан нэмэгдэхээр нь зарвал дээр. Магадгүй 2600 төгрөгт ч хүрч болох юм. Түүнээс ч өндөр болохыг үгүй гэх газаргүй. Одоохондоо ам.долларын ханш тогтвортой байгаа гэх болов ч бага багаар нэмэгдээд л байна. Саяхан 2498 төгрөг байсан бол долоо хоногийн дотор 10 орчим төгрөгөөр нэмэгдчихлээ шүү дээ. Тийм болохоор цагаан сар хүртэл ам.доллараа дарж байгаад зарсан дээр байх.

Урт хугацаандаа ам.долларын ханш буурна

Хөгжлийн банкны 580 саяын бондыг ОУВС-гийн зээлээр дарахгүй гэдэг хувилбар дээр тогтоё л доо. Тэгвэл манайд 450 сая ам.доллар орж ирнэ. Тэгэхээр мэдээж валютын нөөц нэмэгдэж таараа. Ерөнхийдөө гуравдугаар сарын сүүлчээр одоо байгаа валютын нөөц

нэмэгдэж, 1.7-1.8 тэрбумд хүрч, төв банк интервенц хийх хангалттай чадалтай болчих байх. Ингээд л ам.долларын ханш наандаж 10 хувиар унаж, 2300 төгрөгт тэнцэж очих болов уу гэсэн таамаг байгаа юм. Цаашлаад улирлын шинжтэй бууралт ч гарна. Мөн Тавантолгойн асуудал яаж шийдэгдэхээс олон зүйл шийдэгдэнэ. Ерөнхий сайд Тавантолгойг хөдөлгөнө, УИХ-аар хэлэлцүүлнэ гээд байгаа. Цаашлаад томоохон төслүүд хөдлөх шинж ажиглагдаж эхэлсэн. Ер нь бол МАН 65 суудалтай, олонхиийн саналаар ямар ч төслийг хөдөлгөх чадал тэдэнд байна. Дээрээс нь энэ жил Ерөнхийлөгчийн сонгууль болно. Сонгуулийн өмнө эдийн засгаа өөд нь татаж, валютын ханшаа бууруулах арга хэмжээ авах байх. Дээрээс нь ээсийн үнэ дэлхийн зах зээл дээр өсч байна. Гэх мэт энэ засагт боломж олгохоор, гэрэл гэгээтэй зүйлүүд гарч ирж байгаа юм. Хэрвээ эрх баригчид жаахан хурдтай ажиллаад, Тавантолгойг хөдөлгөж, асуудлыг шийдчихвэл валютын ханш буурч таарна. Тэгээд ч ганцхан ОУВС-гийн 450 сая ам.доллараас гадна валютын зээл орж ирэх ч асуудал яригдаж буй. Тиймээс урт хугацаандаа ам.долларын ханш буурах нь тодорхой. Ер нь бол ам.доллар хав дарж, улам үнэд орохоор нь зарах гэж байгаа хүмүүс цагаан сараас хойш гялайна гэж ч байхгүй болов уу даа. Нэг ам.доллараас 50, 100 төгрөг ч хамаагүй харна гэвэл тэгсгээд зарсан нь л дээр байх.



ЧУХАЛ СЭДЭВ

“МАН БОГДЫНХОО БООРЦИЛЖ БАЙГАА”



Аймаас мэдээлж байна

ОРХОН АЙМАГ

Иргэдийн гомдлыг барагдуулахыг холбогдох байгууллагуудад нь анхааруулав

Э.ТУУЛ

Орхон аймгийн Засаг даргын шуурхай хуралдаан өнгөрсөн даваа гарагт болж, аймгийн Засаг даргын орлогч А.Түвшинжаргал, С.Батжаргал нар удирдан явуулав. Энэ үеэр аймгийн Засаг даргын орлогч С.Батжаргал “Булган аймагтай хамтран ажиллах гэрээ байгуулахад тодорхой хугацаа өнгөрлөө. Үүний дагуу өнгөрсөн долоо хоногт Байгаль орчин аялал, жуулчлалын чиглэлээр хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурсан. Үлдсэн байгууллагууд өөрийн чиглэл, чиглэлээр Булган аймагтай хамтран ажиллах гэрээ байгуулах аялаа яаравчлах хэрэгтэй байна. Мөн гэр хорооллын айлуудад хоёр тарифт тоолуур олгох ажлыг “Эрдэнэт Булганы ЦГС” ТӨХК ямар шалтгаанаар саатуулаад байна вэ. Энэ бол төрөөс барьж буй бодлогын ажил. Иргэдээс гомдол ирэх боллоо. Түүнээс гадна СӨХ-дын үйл ажиллагааны талаар иргэдийн гомдол тасрахгүй байна. Тиймээс бүх СӨХ-дын удирдлагуудтай уулзалт зохион байгуулах хэрэгтэй. Уг ажлыг Баян-Өндөр сум ЗДТГ, Хууль эрх зүйн хэлтсээс зохион байгуул. Их залуу багийн нутаг дэвсгэрт нүүрс зарж буй том оврын автомашинууд орчин тойрноо бохирдуулж байгаа талаар иргэдээс гомдол ирсэн. Уг асуудалд холбогдох байгууллагууд нь анхаар” хэмээн үүрэгдлээ. Түүнчлэн аймгийн Засаг даргын орлогч А.Түвшинжаргал “Ижил төрлийн эм, эмийн сангуудад харилцан адилгүй үнэтэй байгаа талаар иргэд гомдол гаргасан. Төрийн байгууллагуудын хийх ажлыг иргэд өөрсдөө хийгээд мэдээлж байна. Мэргэжлийн хяналтын газар эмийн асуудал хариуцдаг улсын байцаагчдаа чиглэл өгч энэ асуудлыг судлах хэрэгтэй. Мөн төрийн байгууллагууд сахилга хариуцлага, төсвийн үр ашгийг сайжруулахад анхаар. Боловсрол, соёл, урлагийн газар, ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс, Хууль эрх зүйн хэлтсээс сургууль, цэцэрлэгүүдийн боловсон хүчнийг өс зүйтэй холбоотой асуудалд анхаарлаа хандуулах хэрэгтэй болсон байна” гэж сануулав. Харин аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Соёлчхүү “Өнгөрсөн долоо хоногт 70353511 утсанд ирсэн нийт гомдлын 60 хувийг нийтийн тээврийн асуудал эзэлсэн байна. Нийтийн тээврийн үйлчилгээнд явж буй тээврийн хэрэгслүүд оройн цагаар хүүхэд аваад сууж буй ахмадуудыг хөөж буулгадаг гэнэ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй зүй бус харьцааг “кондуктор”-уудтай хариуцлага тооцоо ажлыг аймгийн Авто тээврийн төвөөс зохион байгуулах хэрэгтэй байна. Эдгээр гомдлуудыг гаргасан иргэд тухайн тээврийн хэрэгслийн улсын дугаарыг тодорхой хэлсэн. Хоёрдугаарт, такси үйлчилгээнд явж буй тээврийн хэрэгслүүд зогсож буй зогсоолын асуудлыг цэгцлэхэд Авто тээврийн төв анхаарлаа хандуулах хэрэгтэй”-г анхаарууллаа.

ДАРХАН-УУЛ АЙМАГ



Депутатуудад хүндэтгэл үзүүлэв

Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсаны 25 жилийн ой энэ сарын 13-нд тохионо. Энэ өдөр манай улс, үндэстний язгуур эрх ашгийг хамарсан гол харилцааг зохицуулах суурь хуулийг ард түмэнтэйгээ хамтран хэлэлцэж, хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулсан, ардчилсан тогтолцооны үндсийг бүрдүүлсэн шинэ Үндсэн хуулиа баталсан түүхт баярын өдөр юм. Үндсэн хууль батлагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан Дархан-Уул аймгийн ИТХ-ын дарга Г.Эрдэнэбат, Засаг даргын Үйлдвэрлэл дэд бүтэц, хууль эрх зүйн асуудал хариуцсан орлогч Т.Ганболд, Нийгмийн бодлого, төсөл хөтөлбөр хариуцсан орлогч А.Түвшинбат, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга Р.Тунгалаг-Эрдэнэ, ЗДТГ-ын Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга П.Баярсайхан нар тус аймагт ажиллаж амьдарч байгаа шинэ Үндсэн хуулийг батлалцсан депутатуудыг хүлээн авч санал сэтгэгдлийг нь сонсож, хүндэтгэл үзүүллээ. Хүндэтгэлийн уулзалтын үеэр аймгийн ИТХ-ын дарга Г.Эрдэнэбат “Монгол Улсын 1992 онд батлагдсан Үндсэн хуулийг анхны ардчилсан шинэ Үндсэн хууль гэж нэрлэдэг. Үндсэн хуулийн төслийг, Монгол Улсын анхны байнгын парламент болох Улсын Бага Хурал боловсруулж бүх ард түмнээс санал авсны үндсэн дээр Бүгд найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлын 430 депутат, Ардын Их Хурлын чуулганаар 76 хоног хэлэлцэж баталсан нь Монгол Улсад эрх зүйн шинэчлэл хийгдэх шинэ Үндсэн хуульдаа нийцүүлэн бусад салбар хуулиудаар хүний эрхийг илүүтэй баталгаажуулж өгөх боломж нээгдсэн” хэмээн онцолсон юм. Дашрамд дурьдахад, 1992 онд Үндсэн хуулийг батлалцах хэлэлцүүлэгт нийт 1.2 сая иргэний 75 орчим хувь нь оролцож, 200 мянга гаруй санал ирүүлж байжээ.

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ

Сумдын ажлыг дүгнэнэ

Өвөрхангай аймгийн ИТХ-ын ажлын алба, аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газраас долоон ажлын хэсэг томилогдож, 19 суманд энэ сарын 06-15-ны хооронд ажиллахаар болжээ. “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам” батлах тухай Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоол, “Нутгийн удирдлагын байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний журам” батлах тухай аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан журмын хүрээнд төрийн байгууллага, албан хаагчдын ажилтай газар дээр нь биечлэн танилцаж, 2016 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажиллах аж. Түүнчлэн төрийн албан хаагчдыг арга зүйн зөвлөмжөөр хангах, аймгийн Засаг даргын 2016-2020 оны “Бүтээлч Өвөрхангай-2020” үйл ажиллагааны хөтөлбөрийг иргэдэд танилцуулах зэрэг ажлуудыг зохион байгуулах гэнэ.



Б.Жаргалсайхан: МАН сонгуулиар нөгөө мөнгөө тараах байлгүй дээ

/Бүгд найрамдах нам/

“Уг нь зөвхөн МАН-ын эрх ашигт нийцсэн хууль батлах ёсгүй шүү дээ. Харин Монголын ард түмэнд ашигтай хууль батлах хэрэгтэй. Миний харж байгаагаар Үндсэн хуулиа л зөрчсөн хууль гаргах гээд байгаа юм билээ. Иргэд сонгох, сонгогдох эрхээ хаагдуулж, боогдуулж л байгаа бололтой. Сонгуулийг 14 хоногийн дотор хийнэ ч гэх шиг. Нэр дэвшигчид яаж аймгуудаараа явж амжих юм. Тиймээс хугацаа нь дор хаяж сар байх учиртай. Би орж байсан хүн мэдэлгүй яахав. Түүнчлэн сонгуулийн хуульд шударга өрсөлдөөнийг илүү тодотгох ёстой. Нэр дэвшигчдийн халз мэтгэлцээнийг улс орон даяар явуулах хэрэгтэй. Дэлхийн жишиг тэр. АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулиар бүх статусаар явж, Хиллари Клинтон, Дональд Трамп нар халз мэтгэлцэж байгаа биз дээ. Гэтэл манайхан чадахгүй байгаа. Тухайлбал, хамгийн сүүлд Монгол телевизээр шал тэнэг юм Монгол Улсын Үндэсний туг, далбааг тайлбарлаад өгч гэх шиг. Бүр хөх инээдмийн юм асуудаг юм билээ. Энэ мэтээр сонгуулийн хуулийг сайжруулах олон зүйл байгаа. Сонгуулийн сурталчилгааг ил тод болгох хэрэгтэй. Нэгэнт Ерөнхийлөгчийн сонгууль л юм бол түүнд өрсөлдөж байгаа хүмүүс бүгд ил тодоор бүх аймаг, сум, дүүргүүд дээр мэтгэлцсэн зохион байгуулж яагаад болохгүй гэж. Гэхдээ сонгуулиар МАН-ын нам нөгөө мөнгөө тараах байлгүй дээ. Нөгөө богдынхоо боорцийг тараана. Эд нарын ганц чаддаг зүйл нь энэ болчихоод байна.



Н.Дашдаваа: Ард түмэн МАН, АН-ын Ерөнхийлөгчийг хүсэхгүй байгаа

/Монгол Консерватив намын дарга/

“Монголын парламент үеийн үед өөрсөдөө тааруулсан хууль батлахаа болх хэрэгтэй. Өршөөлийн хуулиас эхлээд Ерөнхийлөгчийн тухай хуулийг хүртэл өөрсдийн бүлэглэл, намын хүсэлд нийцүүлэн батлах сонирхол ажиглагдаж байна. Монголчууд өөрсөдөө тааруулж хууль баталдаг эрх баригчдын үхээнд улс төрөөс салах хэрэгтэй. Монгол Улс сонгуулийн нэгдсэн хуультай болж түүгээрээ УИХ, орон нутгийн сонгуулийг явуулсан. Одоо тэр нэгдсэн хуулиараа Ерөнхийлөгчийн сонгуулийг явуулах хэрэгтэй. Хэрвээ тэр хуулиар явуулж болохгүй байгаа бол өмнөх сонгуулиудыг хүртэл эргэж харах хэрэгтэй. Сонгуультай холбоотой хуулийг ингэж дур зоргийн шинжтэй өөрчилдөг бүлэглэлүүд болх хэрэгтэй. Ерөнхийлөгчийн тухай хуулийг аль нэг нам, бүлэглэл өөрийн эрх ашгийг оруулж батлаж болохгүй. 2016 онд эрх баригч намууд нийлж бас л өөрсөдөө тааруулсан хууль баталцаасан. Ингэж сонгогчдийн сонгох эрхэнд халдах үзэгдэл Ардчилсан оронд байж болохгүй. Үндсэн хуулийг зөрчих заалтууд ч байгаа юм. Бас л хүсээгүй сонголтыг ард түмэнд тулгах нь байна. Ард түмэн МАН-аас Ерөнхийлөгч хүсэхгүй байна. Тэднийг хянаж чаддаг, хариуцлага тооцож чаддаг шинэ хүн хүсэж байна. Ард түмний хүсээд байгаа хуулийг батлахгүй мөртлөө өөрсдийн хүссэн хуулийг бол сарын дотор баталдаг бүдүүлэг, ёс суртахуунгүй улс төр МАН, АН-ынханд соёл болж тогтжээ. Монгол коммунистуудаасаа, либералистуудаасаа салаагүй цагт Монгол хөгжихгүй юм байна.

Л.Жаргалсайхан: МАН-ынхан ч өөрсдийнхөө хүсэл зоргоор л хуулиа батлах нь

/Монголын Уламжлалын Нэгдсэн Намын Тамгын газрын дарга/

“Эр нь улстөрчид аливаа сонгуулийн өмнө өөрсөдөө ашигтайгаар хуульд өөрчлөлт оруулдаг болоод байгаа. Энэ удаад МАН-ынхан ч өөрсдийнхөө хүсэл зоргоор л хуулиа батлах нь. УИХ-д суудалгүй улс төрийн намуудын төлөөлөл байр сууриа илэрхийлээд гээд хүчтэй нөлөөлж чадахгүй нь ойлгомжтой байх. Учир нь хэн эрх мэдэлтэй байна. Тэр л өөрт таалагдсан хуулиа баталчихдаг болоод байгаа.



Г.Ганбат: Өөрсөдөө зориулсан хуулийг баталчихдаг болоод байна

/Эх орончдын нэгдсэн намын дарга/

“Нэг улс төрийн хүчин гарч ирэхээрээ л яг өөрсөдөө зориулсан хуулийг баталчихдаг болоод байна. Төрийн хуулиар тоглоод байх юм ямар тоглоом юм уу. Ер нь ард түмний сонгох эрхийг луйварддаг энэ тоглоом бид 26 жил үзэхээрээ нэг болж байна. Бүхэл бүтэн 26 жил шүүмжлэлтэй хандаж, эсэргүүцээд байхад эрх баригчид өөрсөдөө зориулж хууль батлаад байгаа. Энэ удаад ч Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг сайжруулах гээд байгаа юм биш. Хамгийн гол нь өөрсөдөө буюу МАНАН бүлэглэлийн эрх ашгийг л бодоод төрийн хуулиар тоглоод байна. Үүний үр дүнд ард түмний ардчилсан сонголт гэх үнэт зүйлийг байхгүй болгоод байгаа юм. Ер нь Үндсэн хууль, Сонгуулийн хууль гээд ард түмний үндсэн эрхийг хөндөөд байдаг хуулиудыг заавал нийтээрээ зөвшилцож байж л оролдох учиртай. Түүнээс хэн нэгэн нь гарч ирээд л бид олонхи болсон гээд хүчээр хууль батлаад байдаг байж болохгүй биз дээ. Тухайлбал, МАН-ынхан үүний өмнө сөрөг хүчин байхдаа АН-ынхан Сонгуулийн хуулийг өөрчлөх гэж байхад маш хүчтэй эсэргүүцэж байсан. Тухайн үед УИХ-д суудалгүй намууд ч идэвхтэй хамтран ажиллаж байлаа. Харин өнөөдөр Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг батлах гэж байгаа ч биднээс асууж байгаа зүйл алга. Бүр биднийг сонсох нь битгий хэл ард түмнээ ч сонсохгүй байна. Тиймээс энэ хоёр намыг аль алийг нь Монголын төрөөс арчих хэрэгтэй. Уг нь бид шударга ёс, зөв тогтолцоог л нэхээд байгаа болохоос өөр зүйл нэхээгүй.



Ш.Төмөрсүх: Сэжигтэй нөхдүүдийг нэр дэвшүүлэхгүй байх ёстой

/Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч Намын дарга/

“Миний хувьд хуулийг өөрчлөөд Ерөнхийлөгчийн сонгуульд зөвхөн МАН-аас л хүн нэр дэвших эрхтэй болох нь гээд яриад байгаа зүйлд нэг их ач холбогдол өгөхгүй байгаа. Ер нь бол одоогийн Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд шинээр 2-3 юм оруулсан шүү дээ. Тухайлбал, ямар нэгэн гэмт хэргийн сэжигтэн биш гэх зүйлүүд байгаа. Би харин ч үүнийг маш зөв гэж үзэж байгаа. Манайхан чинь УИХ-ын болоод орон нутгийн сонгуулиар шүүхээр тогтоогдоогүй бол тухайн хүн ямар ч хэрэгтэн, сэжигтэн байсан өрсөлдөөд гараад ирдэг байсан. Улмаар нэр дэвшээд гарчихсан хойно төрийн хамгаалалтад орчихоод харин ч улам их хулгай, луйвар хийгээд байдаг. Тиймээс би Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн тэр мэт заалтуудыг нь дэмжиж байгаа. Бүр авлига авсан, идсэн, уусан гэсэн асуудалтай нэр холбогдоод байгаа хүнийг ч нэр дэвшүүлэхгүй байх хэрэгтэй. Түүнээс зах зээл гэж яриад л хулгай, луйварын аргаар баяжиж, хөлжсөн нөхдүүд байна. Тухайлбал, н.Энхболдтой нийлээд Улаанбаатар хотыг худалдаад авчихсан нөхдүүд байхад шүүхээр тэр үйлдэл нь тогтоогддоггүй. Энэ мэт сэжигтэй нөхдүүдийг ч нэр дэвшүүлэхгүй байх ёстой. Харин хугацааны хувьд “сүүлийн зургаан сар заавал Монгол Улсад амьдарсан байна” гэсэн заалт нь жаахан учир дутагдалтай байгаа юм. Ингэж хатуу хугацаа зааж байгаа нь бодит байдалд нийцэхгүй.



ЧУХАМ ЭДЭВ

“ДЭВШИГЧИЙГ Л ТАРААНА”



О.Бум-Ялагч: С.Жавхлан гишүүнд боломж гарч ирнэ

/Монголын Ногоон намын дарга/

-Ер нь ард түмнээ гэсэн бодолтой нэр дэвшигчийг л бид дэмжих бодлого явуулна. Өөрөөр хэлбэл, хүнээ харж л сонголтгоо хийх хэрэгтэй. Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль ямар хууль гарах гээд байна гэхээр Үндсэн хуулийн заалт 45 нас хүрсэн хүн байна. Түүнчлэн гадаадад зургаан сараас дээш хугацаагаар байсан хүнийг сонгохгүй гэх зэрэг заалтууд орж байгаа юм байна. Энэ нь бусад нэр дэвших гэж байгаа буюу олон хүний санал авах магадлалтай хүмүүсийг нэр дэвшүүлэхгүй байх гэж хууль гаргаж байгаа мэтээр яг таараад байна. Тухайлбал, УИХ-ын гишүүн С.Жавхлан 45 нас хүрээгүй гэдэг ангилалд ороод хасагдаж байх шиг байна. Харин Монголд зургаан сарын хугацаагаар амьдраагүй гэсэн заалтаар бол Н.Энхбаяр хасагдах шинжтэй. Тэрбээр Солонгос улсад жил гаруй хугацаанд амьдарсан гэдэг утгаараа. Энэ мэтийг улстөрчид их яриад байгаа. Миний ойлгож байгаагаар хуулийг ажлын хэсэг дээр бусад намуудын төлөөлөл орж ажилласан гэсэн. Бидний харж буйгаар Үндсэн хуульд “45 нас хүрсэн байх ёстой” гэж заасан байдаг. Үүнийг өөрчлөх шаардлага гарч байгаа юм биш биз гэсэн байр суурьтай байгаа. Учир нь Ерөнхийлөгчийн сонгуулийн нийт сонгогчдын бараг тал нь 18-45 насны хүмүүс байдаг. Тэгэхээр Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшиж байгаа хүмүүс дунд залуучуудын төлөөлөл байхгүй болоод байна гэсэн асуудал үүсэх болсон. Түүнчлэн Үндсэн хуулийн “Улс төрийн намын төлөөлөөр нэр дэвшүүлнэ” гэсэн заалт байгаа. Гэтэл энэ нь С.Жавхлан гишүүн чуулганы нэгдсэн хуралдаан дээр “Би хий үзэгдэл юм уу” гэж асууж байсан. Харин АН-ын гишүүн Л.Болд “Хэрвээ 76 гишүүн бүгд бие дааж сонгогдсон бол яах юм” гэж байсан. Энэ мэт хүнд, хүнд асуудал үүсээд буй. Уг нь Үндсэн хуульд Монгол Улсын иргэний баталгаатай эдлэгдэх эрх буюу “сонгох, сонгогдох эрх” гэж байдаг. Тэгэхээр С.Жавхлангийн “сонгох, сонгогдох эрх” нь зөрчигдөөд байгаа. Тиймээс нэг талаас Үндсэн хууль өөрөө зөрчилдөөд эхэлчихсэн байгаа юм. Энэ хүрээнд өөр нэг асуудал нь Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль чинь шинэ хууль шүү дээ. Тиймээс энэ хууль батлагдчихвал өмнөх Сонгуулийн хууль нь хүчингүй болно гэсэн үг. Учир нь хоёр хуулиар сонгууль явуулж болохгүй. Тэгэхээр хүчингүй болох хууль дээр байдаг “УИХ-д сонгогдсон гишүүн өөр намд орохгүй, намаасаа гарахгүй, бие даагч бол ямар нэгэн намд гишүүнээр элсэхгүй” гэсэн заалт байдаг. Тэгвэл энэ заалт хуулиа дагаад хүчингүй болно. Тиймээс С.Жавхлан гишүүн ямар нэгэн намд элсээд, тухайн намаасаа Ерөнхийлөгчийн сонгуульд хүн нэр дэвшүүлэх бололцоотой болж байгаа биз. Тухайлбал, Ц.Нямдорж гишүүнийг МАН-ынхан нэр дэвшүүлэхгүй М.Энхболдыг нэр дэвшүүлж болно. Тэгвэл С.Жавхлан гишүүн Монголын Ногоон намд элсээд тухайн намдаа Ц.Нямдорж гишүүнийг элсүүлээд, нэр дэвшүүлэх боломж байгаа. Тиймээс С.Жавхлан өөрийнхөө төлөөллийн хүнийг нэр дэвшүүлэх гарц Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль батлагдсанаар гарч ирнэ. Үүнийг улс төрийн хүчнүүд ажиглахгүй байх шиг байна.



Б.Цогтгэрэл: Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийг сулруулсан байна

/МУАН-ын дарга/

-Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг зарим гишүүд жаахан улс төржөөд л байх шиг байна. Уг нь нээх том өөрчлөлт байхгүй байх шиг байгаа юм. Өмнөх хуульд ч Үндсэн хуулийн заалттай яг л эдгээр заалтууд байсан. Харин ч энэ удаагийн хуулиар сулруулсан заалтууд байна. Тухайлбал, Ерөнхийлөгчийн сонгууль нэр дэвшигч заавал Монгол аав, ээжээс төрсөн байх зэрэг заалтууд суларсан байгаа юм билээ. Уг нь Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулиа улам л бэхжүүлэх учиртай. Түүнээс улс төрчдийн яриад байгаа УИХ-д суудалтай намаас л нэр дэвших, 45 нас хүрсэн байх зэрэг бол өмнөх хуульд ч байсан Үндсэн хуулийн заалттай зүйлүүд юм. Хэрвээ эдгээр заалтуудад зарим улстөрчид шүүмжлэлтэй хандаж байгаа бол Үндсэн хуульдаа л өөрчлөлт оруулах хэрэгтэй. Ер нь бид Ерөнхийлөгчийн сонгуульд нэг их ач холбогдол өгөхгүй байна. Учир нь ингэж бужигнаж байгаад хэн нэгэн нь гарна. Яг л өнөөдрийн бахь байдаг зүйл л байдгаараа л байна. Тиймээс бүр Үндсэн хуульдаа л өөрчлөлт оруулах хэрэгтэй. Түүнээс одоогийн яриад байгаа энэ Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулиас болоод олон зүйл өөрчлөгдөөд сүйд болно гэж бодохгүй байна.



Ж.Сүхжаргалмаа: Энэ удаагийн хуулиар харгис зохицуулалтаас салах хэрэгтэй

/Иргэний хөдөлгөөний намын Улс төрийн Дэд дарга/

-Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг бие даасан хууль болгох гэж байгаа бол хамгийн ардчилсан үзэл санаагаар хийх хэрэгтэй байна. Тэгээд ч зөвхөн УИХ-д суудалтай намууд л хүнээ Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшүүлдэг явдал бол хамгийн харгис зохицуулалт. Тиймээс энэ удаагийн хуулиар энэ харгис зохицуулалтаас салах хэрэгтэй байна. Дэлхийн жишиг буюу жинхэнэ ардчилсан ёсоор хийнэ гэвэл бие даагч ч Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшүүлдэг байх учиртай. Ер нь бол Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль УИХ болоод орон нутгийн сонгуулийн хууль тогтоомжийн сул талыг маш сайн харгалзаж, үзээд түүнээс ангижирсан хууль л батлагдах хэрэгтэй. Өнөөдрийг хүртэл бол манай улс харгис хууль тогтоомжтой, байгын ухралт хийж явж ирсэн. Тиймээс энэ байдлаа л Мэргэжлийн Засгийн газар засч залруулахгүй бол ард түмний хүлээлт талаар болох гээд байна. Хэр чадамжтай Засаг вэ гэдгээ энэ Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулиар ард түмэндээ харуулах болно.



Г.Уянга: Яг аль заалт нь хэнийг сандаргаад байгаа юм бол

/Тусгаар тогтнол, эв нэгдлийн намын дарга/

-Сонгууль иргэдэд хэзээ ч сонголт өгдөггүй гэдгийг эхлээд ойлгох хэрэгтэй. Сонгомор байгаа хүн чинь саналын хуудсан дээр байхгүй, намгүй, ер нь л дэвшихгүй. Тэгэхээр тулгалтаар урд чинь өрсөн 2-3 хүнээс сонгоно. Урд чинь Coca Cola, Pepsi Cola хоёр л байна. Та аль нэгийг нь сонгоно. Алийг нь ч сонгосон Кола л уух болно. Алийг нь ч сонгосон нэг л эзэн ашиг олох болно. Товчдоо манай сонгууль ийм л юм болно доо. Сонгуулийн хуулиас онцгой сайжруулсан, бас муужруулсан заалт би олж харсангүй. Яг аль заалт нь хэнийг сандаргаад байгаа юм бол. Сонгогчдын тухайд ямар ч хууль гаргаад ашигтай биш. Энэ хоёр Колагийн алийг нь ч сонгосон ямар ч дэвшил байхгүй гэж хэлмээр байна.



О.Заяа: Хуулийг хэрхэн батлаад байгааг ажиглаж байгаа

/Хөгжлийн Хөтөлбөрийн Намын дарга/

-Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг батлах гэж байгаа гэсэн. Гэтэл УИХ-д суудалгүй нам эвсэл ямар байр суурьтай байгаа нь эрх баригчдад огт хамаагүй бололтой юм. Эд нар өөрсөддөө ашигтайгаар хуулийг баталдаг болоод байгаа. Тиймээс энэ удаад ч МАН-ынхан өөрсдийнхөөрөө л батлах байх. Бид ямар нэгэн байдлаар байр суурна илэрхийлээд ч нөлөөлөхгүй гэдэг нь ойлгомжтой. Тиймээс бид хуулийг хэрхэн батлаад байгааг ажиглаад л байж байна. Харин хуулийг батлаад сүүлд нь гарах үр дүнгээс болж бид асуудал хандах болно.



Л.Гүндалай: Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн хэлэлцэж байгааг ойлгохгүй байна

/Ард түмнээ хайрлаж намын дарга/

-Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийг хэлэлцэж байгаа гэсэн. Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль юу нь болохгүй болоод өөрчлөх гээд байгааг ойлгохгүй байна. Өмнөх хууль нь зүгээр л байгаа шүү дээ. МАН-ынхан тайлбарлахдаа СЕХ-ноос бүх сонгуулийг нэг хуулиар зохицуулах нь төвөгтэй байна. Тиймээс тусдаа хуультай болох гэж байна гэсэн зүйл яриад байсан. Сонгуулийн ерөнхий хороо л сонгууль явуулахад төвөгтэй байна гэж хэлсэн болохоор л Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийг хэлэлцэж байгаа гэнэ. Яасан чих зөөлөнтэй болчихсон юм.

УРИЛГА

БНХАУ-ЫН ТЯНЬЖИН БООМТЫН ДУНЗЯНЫ ЧӨЛӨӨТ ХУДАЛДААНЫ БООМТ БҮСЭД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТЭЭВЭР ЛОЖИСТИКИЙН ТӨСӨЛД ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын “Далайд гарах боломжийг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 2013 оны 152 дугаар тогтоолын хүрээнд БНХАУ-ын Тяньжин хотын Дунзян чөлөөт худалдааны боомт бүсийн 10 га газарт Хятадын талтай хамтарсан компани байгуулж “Тээвэр ложистикийн төв” төслийг хэрэгжүүлэх, энэхүү төсөлд хөрөнгө оруулж, хамтран ажиллах боломж бүхий дотоодын хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг хамтран ажиллахыг урьж байна.

Санал ирүүлэх компаниудад тавигдах шаардлага

- Компани татварын өргүй;
- Санхүүгийн чадамжтай;
- Тогтвортой, удаан хугацаанд хамтран ажиллах.

Санал авах хугацаа

Саналыг 2017 оны 2-р сарын 15-ны өдрийг хүртэл хугацаанд “Монголын төмөр зам” ТӨХК-д албан бичгээр эсвэл baigalmaa@mtz.mn цахим хаягаар ирүүлнэ үү.

Хаяг:
 “Монголын төмөр зам” Төрийн Өмчит Хувьцаат Компани Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайвны өргөн чөлөө-23, UBН центр, 8-р давхар Улаанбаатар 14230
 Утас: (976) 99140072
 Факс: (976) 70106644
 Вебсайт: www.mtz.mn

ДЭЛХИЙ



БНСУ Японд буулт хийх нь

Б.ДАВААХҮҮ

Дэлхийн II дайны үед Японы Эзэн хааны армийн цэргүүдийн бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан солонгос эмэгтэйчүүд буюу "зугаацуулагч эмэгтэйчүүд"-ийн дурсгалд зориулсан хөшөөг Бусан хот дахь Японы Ерөнхий Консулын газрын өмнө шинээр байрлуулсан явдалтай холбоотойгоор Япон, Солонгосын харилцаа дахин муудаж эхэллээ. Учир нь уг хөшөөний асуудлаар хоёр улс хэлэлцээрийн ширээний ард сууж, аль хэдийнэ 2015 онд тохиролцоонд хүрсэн аж. Гэтэл саяхнаас дахин хөшөөг Бусан хотод байрлуулсныг эсэргүүцэн Япон улсаас Өмнөд Солонгост суугаа Элчин сайд Ясүмасэ Нагаминэ, Ерөнхий Консул Ясүхиро Моримото нарыг эгүүлэн татсан юм. Тэд уржигдар эх орондоо ирсэн. Одоогоор Япон, БНСУ-ын Засгийн газар хооронд яриа хэлэлцээр

өрнөж байна. Уг хөшөөг Өмнөд Солонгосын иргэний нийгмийн нэгэн байгууллага өнгөрсөн арванхоёрдугаар сарын сүүлчээр Японы Ерөнхий Консулын газрын өмнө байрлуулжээ. Улмаар тохиролцоонд хүрчихээд байхад дахин "Зугаацуулагч эмэгтэйчүүд" хөшөөг байрлуулсныг Японы тал эсэргүүцэн даруй холдуулахыг шаардсан байна. Гэтэл БНСУ-ын талаас тоймтой хариу өгөлгүй, хоёр жилийн өмнө хэлэлцээрийн заалтыг үл биелүүлсний улмаас Японы Элчин сайд, Бусаны Ерөнхий Консул нарын хүмүүс эсэргүүцтэй илэрхийлэн нутаг буцжээ. Энэ асуудалтай холбоотойгоор өчигдөр Японы Ерөнхий сайд Шинзо Абэ нарын Засгийн газрын албан тушаалтнууд Японоос БНСУ-д суух Элчин сайд, Ерөнхий Консул нарын эрхмүүдийг хүлээн авч уулзаж, уг асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар ярилцжээ. Гэвч уулзалтаар ямар шийдэлд хүрсэн талаар

дэлгэрэнгүй мэдээлэл байхгүй байна. Гэхдээ Японы сайд нарын танхимын ерөнхий нарийн бичиг Ёшихидэ Суга уулзалтын дараа хэвлэлийн бага хурал зарлаж мэдээлэл өгөхдөө "2015 оны Япон, БНСУ-ын гэрээнд зугаацуулагч эмэгтэйчүүдийн асуудлыг эцсийн байдлаар шийдвэрлэсэн. БНСУ-ын Засгийн газар ч "Гэрээг цаашид тогтвортойгоор хэрэгжүүлэх талаархи байр сууриа өөрчлөхгүй" гэдгээ илэрхийлсэн. Тиймээс Солонгосын талаас уг гэрээг хэрэгжүүлэхийг шаардаж байна" гэсэн байна. Мөн БНСУ-д суух Элчин сайдыг буцаах хугацааны талаар "Одоогоор тодорхойгүй" гэх хариултыг өгчээ. Нөгөөтэйгүүр, БНСУ-ын Ерөнхийлөгчийн үүргийг түр орлон гүйцэтгэж буй Ерөнхий сайд Ким Бён Жун өчигдөр болсон Засгийн газрын хуралдааны үеэр "Зугаацуулагч эмэгтэйчүүдийн дурсгалд зориулсан хөшөөтэй холбоотойгоор БНСУ, Японы

харилцаанд санаа зовоосон асуудал" тулгарсныг дурьдаад хоёр улсын харилцаа нэг асуудлаас үүдэн дахин муудаж буйд харамсч буйгаа илэрхийлжээ. Тэрбээр "Хуучин Японы эзэн хааны цэргүүдтэй холбоотой асуудалд Японы Засгийн газраас хариуцлагаа хүлээж, гэмшиж буйгаа илэрхийлсэн. Улмаар хохирогчид болон тэдний ар гэрийнхэнд санхүүгийн дэмжлэг үзүүлж, тэдний нэр төрийг сэргээхээр болсон" хэмээгээд "Нөхцөл байдлыг улам муутгахүйлажиллагаанаас аль болох зайлсхийж, хоёр улсын харилцааны ирээдүйн хөгжлийн төлөө анхаарвал зохино" гэжээ. Ямартай ч, Ерөнхийлөгчийн үүргийг түр орлон гүйцэтгэж буй эрхэм ийм үг хэлж буй учраас БНСУ Японы талд буулт хийх нь ойлгомжтой боллоо. Харин "Зугаацуулагч эмэгтэйчүүд"-ийн дурсгалд зориулсан хөшөөг хэзээ зайлуулах нь олны анхаарлыг татаж байна.

Доналд Трампт хүргэн нь зөвлөнө

АНУ-ын шинэ Ерөнхийлөгч Доналд Трамп том охин Иванка Трампын нөхөр болох үл хөдлөх хөрөнгийн бизнесмэн Жаред Кушнерыг өөрийн зөвлөхөөр томилно гэдгээ мэдэгдлээ. Тэрбээр "Жаред сонгууль болон шилжилтийн засаг захиргаанд та бүхний мэдэж байгаагаас ч илүү гол хүн байх болно. Түүнтэй хамтран ажиллах болсондоо баяртай байна" гэж хэлжээ. Өчигдөр 36 насны төрсөн өдрөө тэмдэглэсэн Кушнер шинэ Ерөнхийлөгч Доналд Трампын кабинетын хамгийн залуу нь болж байгаа юм. Өнгөрсөн жилийн сонгуулийн тулааны үеэр хадам эцгийнхээ арын албыг хашиж явсан тэрбээр ялалтад нь хамгийн их үүрэг гүйцэтгэсэн гэдэг. Гэхдээ Жаред Кушнерыг зөвлөхийн албан тушаалд томилоход хууль эрх зүйн талаасаа бэрхшээл гарч болзошгүй гэнэ. АНУ-д Ерөнхийлөгч асан Жон Ф.Кеннеди дүүгээ чухал албан тушаалд томилсны улмаас эсэргүүцэл дагуулж, улмаар хамаатан саднаа төрийн албанд томилохыг хуулиар хориглож байжээ.

Тэгэхээр уг хуулийн дагуу Доналд Трамп хүргэнээ зөвлөхийн албан тушаалд томилох боломжгүй юм. Гэхдээ Трампын зөвлөхүүд Засгийн газарт бус, Цагаан ордонд хамаарах тул хатуу шалгуур тавихгүй гэдгийг зарим эх сурвалж онцолж байна. Нью-Йоркийн бизнесмэн, үл хөдлөх хөрөнгийн магнат Дональд Трамп нэгдүгээр сарын 20-нд Капитол Хиллд тангараг өргөж, АНУ-ын 45 дахь ерөнхийлөгчөөр томилогдох билээ.

"Hollywood"-ыг "hollyweed" болгосон этгээдийг баривчилжээ

АНУ-ын Калифорни мужийн Лос-Анжелес хотын толгод дээр байрладаг алдарт "Hollywood" гэх үг энэ сарын 1-нээс эхлэн "hollyweed" болон өөрчлөгдсөн хэрэг гарсан. Гэвч үсгийг сольсон этгээд хэн болох нь тодорхойгүй байсан юм. Тэгвэл Лос-Анжелес хотын цагдаагийн газраас шуурхай ажилласны дүнд сэжигтний оршин суугаа хаягийг тодруулан баривчилсан байна. Үсгийг Зачари Коль Фернандез гэгч этгээд сольсон байжээ. Түүнийг хөнгөвтөр гэмт хэрэг үйлдсэн гэх үндэслэлээр саатуулсан аж. Гэхдээ түүнийг шүүх хурлыг ирэх сарын 15-нд товлож, сэжигтнийг батлан даалтад гаргалаа. "Есүсийн гар" гэх хоч нэрээр үйл ажиллагаа явуулдаг Фернандез "Vice" гэх сэтгүүлд өгсөн ярилцлагадаа "Hollywood" гэх үгийг "O" үсгийг хамтран амьдрагчийнхаа хамт "E" үсгээр сольж болох эсэхийг нь мэдэх зорилгоор дүрсгүйтсэн гэдгээ хүлээн зөвшөөрсөн байна.



ЭМГЭНЭЛ

Монгол Улсын боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухааны нэрт зүтгэлтэн, Монгол Улсын Гавьяат багш, Анагаах ухааны доктор, профессор Гомбосүрэнгийн БАТМӨНХ 2017 оны 1 дүгээр сарын 06-ны өдөр зуурдаар таалал төгсөж, бидэнд нөхөж баршгүй хүнд гарз тохиолоо.

Монгол Улсын Гавьяат багш, Анагаах ухааны доктор, профессор Гонсрон овогт Гомбосүрэнгийн БАТМӨНХ 1936 онд Сүхбаатар аймгийн Сүхбаатар суманд (хуучнаар Дарханхаан сум) төржээ. 1945 онд сумын бага сургуульд элсэн орж, 1955 онд аймгийн төвийн 10 жилийн дунд сургуулийг төгссөн. МУИС-ийн Хүнэмнэлгийн факультетэд 1955-1960 онд суралцан Хүний их эмч мэргэжил эзэмшин төгссөн байна.

Эрүүлийг Хамгаалах Яамны Боловсон хүчний хэлтэст 1960-1963 онд ахлах байцаагч, хэлтсийн эрхлэгч болон Дээд боловсролын хорооны гишүүнээр ажиллах хугацаандаа эрүүлийг хамгаалах салбарын өнөөгийн байдал ба цаашдын хөгжлийн бодлого боловсруулан хэрэгжүүлэх, гадаад харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх, БНМАУ-ын Хүний их эмчийн тангарагийн үг болоод тангараг өргөх журмыг боловсруулах, эмч эмнэлгийн ажилтнуудыг гадаад орнуудад суралцуулан мэргэшүүлэх зэрэг цаг үеийн чухал ажлуудад анхаарч, манлайлан оролцож байв.

Тэрээр 1961 онд Анагаах ухааны хүрээлэн, 1962 онд Дорноговь аймгийн Анагаах ухааны дунд сургуулийг үүсгэн байгуулахад гар бие оролцон, тулгын чулууг нь тавилцаж, гал голомтыг бадрааж байжээ. Улсын хэмжээнд эмч нарын бүртгэлийн нэгдсэн тогтолцоо, мэргэжилтэй боловсон хүчний мэдээллийн нэгдсэн санг үүсгэх ажлын үндэс суурийг тавьсан хүн бол бидний хүндэт багш Г. Батмөнх профессор юм.

Профессор Г.Батмөнх 1963-2009 онд АУДЭС, АУИС, ЭМШУИС-д багш, тэнхимийн эрхлэгч, орлогч декан, декан, эрдэмтэн нарийн бичгийн дарга, зөвлөх профессор зэрэг албанд хагас зуун жил ажилласан, эрдмийн их өргөөний ноён оргилуудын нэг нь байсан билээ. Ажиллах хугацаандаа 1967, 1980, 1989 онуудад Зөвлөлт Холбоот Улсад (одоогийн ОХУ) суралцан, Монгол улсад физиологийн шинжлэх ухааныг хөгжүүлэхэд түүчээлэн манлайлсан, Монголын физиологичдийн их гэр бүлийн хүндэт гишүүн нь байлаа. Эрхэм багшийн маань оюунлаг эрч хүч, хөдөлмөр зүтгэл, хүнлэг энэрэнгүй зан чанар нь Монголын эрүүл мэндийн салбарын үе үеийн эмч, мэргэдэд анагаах эрдмийг хүртээх, үндэсний эрдэмтэн судлаачдыг

өгсөн бойжуулахад үнэлж баршгүй ундарга нь болж байв. Профессор Г.Батмөнх багшийн ухамсарт амьдралын эрч хүч нь эрдэм судлалын ажилд зориулагдсан бөгөөд эрдэм шинжилгээний 200 гаруй бүтээлийг туурвиж, хагас зуугаар тоологдох гарын шавь нарыг бэлтгэсэн номын их багштан байлаа. Тэрээр 1981 онд "БНМАУ-ын өндөр уулын нутгийн хүмүүсийн зүрх судасны тогтолцооны физиологийн зарим үзүүлэлтийн онцлог" сэдвээр Анагаах ухааны докторын зэрэг хамгаалсан юм.

Багш маань ЭХЯ, АУДЭС-ийн намын үүрийн товчооны гишүүн, багш нарын намын үүрийн дарга, их сургуулийн үйлдвэрчний нэгдсэн хорооны дарга, намын хорооны товчооны гишүүн, хот дүүргийн МАХН-ын бага хурлын гишүүн, Их сургуулийн болон НЭМХ-ийн эрдмийн зөвлөлийн гишүүн, эрдэмтэн нарийн бичгийн дарга, Монгол улсад Анагаах ухаанаар докторын зэрэг олгох эрдмийн зөвлөлийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, Энэрэл сувилалын сургуулийн ТУЗ-ийн дарга зэрэг сонгуульд ажлуудыг нэр төртэйгээр гүйцэтгэж явсан төр, нийгэм, олон нийтийн зүтгэлтэн байлаа.

Профессор Г.Батмөнх багшийн хөдөлмөр бүтээлийг төр, засгаас өндрөөр үнэлж Ардын хувьсгалын 60, 80, 90-н жилийн ойн медаль, Залуу үеийг халамжлан хүмүүжүүлэгч тэргүүний ажилтан, МХЗЭ-ийн 60 жилийн ойн медаль, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон, МАХН-ын Хүндэт тэмдэг, МАН 90 жил, Боловсрол соёл шинжлэх ухаан 90 жил, ЭМШУИС 70 жил хүндэт тэмдэг, ЭМШУИС-ийн Эрдэнийн очир медаль, Монгол улсын Эрүүлийг хамгаалахын, Ардын боловсролын, Шинжлэх ухааны тэргүүний ажилтан цол, тэмдгээр тус тус шагнасан. 2002 онд Монгол улсын гавьяат багш цол хүртээсэн юм.

Профессор Г.Батмөнх нь Монгол улсын Эрүүл мэнд, Анагаах ухаан, Дээд боловсролын салбарт мэргэжлээрээ овоглуулсан ноён оргилуудын нэг, Эрүүл ба Эмгэг физиологийн тэнхимийн хамт олны өмөг түшиг, Монголын эрүүл мэндийн салбарын үе үеийн эмч мэргэжилтнүүд, эрдэмтэн профессор, багш судлаачдын хайртай багш нь байлаа. Хэн бүхнийг элэгсэг дотно, халуун бүлээн инээмсэглэлээрээ тосч угтдаг, бүхнийг эвлүүлж, ухааруулж, халамжилж, хайрлаж чаддаг, хүн чанарын дээд нь болсон эрхэм их багштан байлаа.

Түүний ажилч хичээнгүй, ухаалаг, шударга, хүнлэг чанар, өгөөмөр сэтгэл, инээмсэглэсэн гэгээн дүр нь бидний зүрх сэтгэлд үүрд мөнхрөн дурсагдах болно.

Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль
Эм зүй, Био анагаахын Сургууль
Эрүүл ба эмгэг физиологийн тэнхим
Монголын Физиологичдийн Нийгэмлэг



Монгол Улсын Гавьяат Багш
Гомбосүрэнгийн БАТМӨНХ
(1935-2017)

ОНЦЛОХ ХУУДАС

Speak out



ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛЭЭ ДЭМЖИЖ БОЛНО, ГЭХДЭЭ ЧАНАРТАА АНХААР

Н.БАТЗАЯА

Үндэсний уламжлалт сар шинийн баяр хаяанд ирж буй. Үүнтэй зэрэгцээд ирсэн зочдын гарыг цайлгах бэлэг бэлдэх хүндхэн ажилтай иргэд учирдаг. Тэгвэл улс оронд эдийн засгийн хямрал нүүрлэсэнтэй холбогдуулан үндэсний үйлдвэрлэлээ дэмжиж сар шинийн бэлгээ дотоодын бараа бүтээгдэхүүнээр бэлдэх аль эсвэл мөнгө бэлэглэж дотооддоо эдийн засгийн эргэлт хийе гэх уриалга цахим ертөнцөд тарсан. Тиймээс энэ асуудлаар иргэдтэй уулзаж "Speak out" бэлтгэлээ.

Гэрэл зургийг Г.АРТУУЖИН



С.Эрдэнэцогт: Үндэсний үйлдвэрлэлээ дэмжиж болох ч чанаргүй бараатай

-Мэдээж тэгэлгүй яах, вэ. Манайх ер нь үндэсний үйлдвэрийн бараа авдаг. Өнгөрсөн жил гэхэд л "Монос"-ын гоо сайхны бараа авч, бэлэглэсэн. Тэр их зүүгээр юм билээ. Үндэсний үйлдвэрлэлээ дэмжиж болно. Гэхдээ нэг асуудал байна. Нэгдүгээрт,

манай Монголын үйлдвэрийн бараа бүтээгдэхүүн чанаргүй байдаг. Хоёрдугаарт, их үнэтэй. Хүнд бэлэглэхийн аргагүй тийм л чанаргүй бараа байдаг шүү дээ. Мэдээж эдийн засгийн хямралтай үед үндэсний үйлдвэрлэлээ дэмжиж, дотооддоо

мөнгөө эргэлдүүлэх нь зөв. Гэхдээ манайх энэ жил хүмүүст мөнгийг нь өгөхөөр болсон. Тэр нь дээр юм билээ.



Ж.Цэцэгмаа: Энэ жил мөнгө бэлэглэнэ

-Дэмжиж байгаа. Ер нь хүмүүс үндэсний үйлдвэрлэлээ дэмжиж саналтай байх шиг байна. Миний

эргэн тойрондох хүмүүс үндэсний үйлдвэрийн бараа авна гэж ярьцгааж байна билээ. Тэгэхээр манайх ч гэсэн тийм бодолтой байгаа. Болсон болоогүй хятадын оймс өгч байхаар үндэснийхээ сайхан барааг өгсөн нь дээр байлгүй яах вэ. Гэхдээ нэгж бэлэглэвэл илүү дээр юм болов уу гэж бодож байгаа. Монгол хүн чинь цагаан сараар ирсэн зочиндоо нэг бэлэг

өгдөггүй. Тийм учраас манайх үндэсний үйлдвэрийн шоколад, нэгжтэй бэлэглэхээр болсон. Яг үнэндээ бид сар шинийн баяраа хэзээ тэмдэглэхээ ч мэдэхгүй л явж байна. Нэг хэсэг нь энэ сарын 27 гэх юм. Нөгөө хэсэг нь хоёрдугаар сарын 27-нд гээд хоёр үзүүртэй зүйл ярьж байна. Үүнийг ч гэсэн нэгдсэн журмаар тогтоох хэрэгтэй шүү дээ. Тэгэхгүй бол над шиг

хөгшин настай хүмүүст жаахан хэцүү л юм. Бэлэгийн хувьд гэвэл үндэсний үйлдвэрээ дэмжинэ.



Д.Баярхүү: Дотоодын компаниуд иргэдийн урмыг хугалах хэрэггүй

-Үндэсний үйлдвэрлэлээ дэмжье гэдэг уриа явж байна. Миний бодлоор үндэсний үйлдвэрүүдээ дэмжиж болно. Гэхдээ үндэсний үйлдвэрлэгч гэх компаниуд худалдаанд гаргаж байгаа бараа, бүтээгдэхүүнээ маш чанартай

хийх хэрэгтэй байна. Монгол хүмүүст нэг нэгнээ дэмжье гэсэн сайхан сэтгэл байна. Тэр сайхан сэтгэлтэй хүмүүсийн урмыг нь хугалж болохгүй. Үндэсний үйлдвэрлэлээ дэмжинэ гээд нэг бараа авдаг авсан бараа нь чанаргүй, энэ тэндээ уранхай цоорхой, өрөөсөн байж

болохгүй биз дээ. Хэрвээ үндэсний бараа болохгүй байвал мөнгийг нь өгсөн нь дээр л дээ. Эдийн засгийн хямралтай үед хүн бүрт л мөнгө хэрэгтэй байгаа шүү дээ.



Ш.Шогтбаатар: Эх орныхоо барааг худалдан авдаг

-Манайх цагаан сарын бэлгээ ихэвчлэн эх орондоо үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээр бэлддэг. Нарантуул захаас бэлэг авдаггүй. Худалдааны төв, Монголд үйлдвэрлэв гэсэн дэлгүүрээр л явдаг. Би бэлэг авахаар

бол үндэснийхээ барааг аваад, авахгүй бол таван төгрөг гар дээр нь тавьчих хэрэгтэй гэж боддог. Энэ бол зөв алхам. Эдийн засаг хямралтай байгаа үед мөнгөний урсгалаа гадагш гаргаад байх тийм ч сайн биш.

бүтээгдэхүүнийг хямдруулах хэрэгтэй. Ингэж л харилцан ажиллахгүй бол ядуу иргэд тэр үнэтэй барааг худалдаж авч чадахгүй. Манайх үндэсний үйлдвэрлэлээ дэмжинэ. Ер нь гэр бүлээрээ тэгж ярьж байгаа.

Н.Мэндээ: Үндэсний үйлдвэрлэлээ дэмжинэ

-Манайх жил бүр Нарантуул худалдааны төвөөс цагаан сарын бэлэг худалдаж авдаг. Гэхдээ заримдаа

нэмж үндэсний үйлдвэрийнхээ барааг худалдаж авдаг. Энэ жил эдийн засгийн хямралтай байгаа талаар хүн бүр ярьж байна. Нэгэнт улс орон хямралтай байгаа үед үндэсний үйлдвэрээ дэмжсэн нь зөв гэж бодож байна. Тэртээ тэргүй бид үргэлж хятадын болсон болоогүй бараа худалдаж авдаг шүү дээ. Түүнийхээ оронд үндэсний

үйлдвэрлэлээ дэмжвэл гадагшаа мөнгөний урсгал гарахгүй юм. Яах вэ, зарим үндэсний бараа бүтээгдэхүүнүүд хэт үнэтэй байдаг. Үүнээс болж иргэд тэр бүр худалдаж авч чаддаггүй. Худалдан авах чадахгүй болохоороо эргээд л хямд үнэтэй хятадын барааг сонгож байгаа юм. Тэгэхээр төр засгаас ч гэсэн дотоодынхоо үйлдвэрийн бараа

оронд мөнгө өгчих хэрэгтэй. Тэр нь л дээр байх гэж бодож байна.

Т.Оюунбилэг: Мөнгө бэлэглэсэн нь дээр

-Манайх цагаан сарын баяр тэмдэглэдэггүй л дээ. Гэхдээ монгол хүнийхээ хувьд үндэсний үйлдвэрээ дэмжих нь зөв гэж бодож байна. Сошиалаар явж байгаа уриалгыг дэмжиж байна. Цагаан сар үндэсний

уламжлалт баяр. Энэ баяраар бид ах дүү, хамаатан саднаараа уулзаж, баярладаг. Нэг ёсондоо гэр бүлийн баяр гэж хэлж болно. Тийм учраас чанартай бэлэг өгсөн нь дээр. Хэрэггүй, чанар муутай, уранхай, цоорхой ойм өгөхийн



Тал нутгийн цахим мэдээлэл



STRESS

Огдын ЦАТ

Жэки Чан:

Чуулбарынхээ үеэр үхэх дөхсөн удаа 7 бий

Орчуулсан: Б.СУМБЯА

Адал явдалт, тулаант киноны төрөлд тод гэрэлтэх болсон од Жэки Чан кино урлагт хагас зуун жил хүчин зүтгэхдээ нэг ч удаа Оскарын шагнал хүртэж байгаагүй юм. Саяхныг хүртэл ишүү дээ. Харин Америкийн кино академиас өнгөрсөн онд түүнийг Оскарын хүндэт шагналд тодорхойлж, гардуулсан нь нэрт жүжигчнийг хийгээд дэлхий даяарх олон олон шүтэн бишрэгчийг нь баярлуулж байсан удаатай. Ингэснээр найтан настайгаасаа хойш кино урлагт хүчин зүтгэх болсон тэрбээр Оскарын хүндэт шагнал хүссэн найт даху хүн болсон билээ. Тэрбээр 1996 онд "Rumble in the Bronx"-т тоглосноос хойш ялангуяа "Оргил цаг", "Шанхайн үд дүнд", "Шанхайн баатрууд", "Дэлхийг 80 хоногт тойрсон нь", "Каратэч хүү" болон "Кунг-Фу Панда" зэрэг кинонд тоглосноор дэлхий даяар маш их нэр хүндийг олсон юм. Ингээд түүний товчхон эрлэцлэгийг энэ удаагийн "Огдын цаг" буланд аорчуулан хүргэж байна.

ДУУЛГАХ СОНИН

"Япон киноны өдрүүд" ТЭНГИС

КИНО ТЕАТРТ БОЛНО



Монгол Японы найрамдалт харилцаа тогтоосны 45 жилийн ойд зориулан "Япон киноны өдрүүд" энэ сарын 18-20-ны өдрүүдэд Тэнгис кино театрт зохион байгуулагдаж гэж байна. "Япон киноны өдрүүд"-ийн хүрээнд ихэвчлэн хөдөө аж ахуйтай холбоотой, хэрхэн хөдөлмөрлөж байгаа талаар ихээхэн сургамжтай кинонуудыг дэлгэцнээ гаргаж, олны хүртээл болгохоор зорьжээ. "Япон киноны өдрүүд"-д зориулсан кинонууд гурван өдрийн турш 15:00, 18:00 цагуудаас Тэнгисийн дэлгэцнээ гарах юм байна.

-Кино урлагт оруулсан хувь нэмрийг тань үнэлж, Америкийн кино академи Оскарын хүндэт шагналыг олгосон. Таны сэтгэгдлийг сонсоор байна?

-Би үнэндээ Оскарын хүндэт шагнал авна гэж хэзээ ч төсөөлж байсангүй. Адал явдалт, тулааны үзүүлбэрт кино урлагийн хөгжлийн төлөөх хичээл зүтгэлээ үнэлүүлж, Оскарын хүндэт шагнал хүртэх тэр мөч өнөөдрийг хүртэл мэдэрч байсан тэр мэдрэмжүүдээс хамгийн бахархмаар нь байсан. Тэр үед шагналынхаа талаар төдийлэн сайн мэдэхгүй, зүгээр л адал явдалт, тулаант киноны хөгжилд оруулсан хувь нэмрийг маань үнэлж байгааг л мэдэж байлаа. Гэтэл шагналаа авсны дараа нэг л тийм өөр мэдрэмж төрсөн.

-Кино урлагт 56 жил зүтгэсний эцэст Оскарын шагнал хүртлээ ишүү дээ. Энэ хугацаанд 200 гаруй кинонд тоглож, олон ч ясаа хугалсан талаар та шагналаа гаргаж авахдаа хэлж байсан. Тэдгээрээс хамгийн хэцүү нь аль кино байв. Бас яагаад гэдгийг нь тайлбарлаж өгөөч?

-1995 онд дэлгэцнээ гарч байсан найруулагч Стэнли Тонгийн бүтээл "Rumble in the Bronx" кино л хамгийн хэцүү нь байсан болов уу. Маш олон тулааны үзэгдэл, аюултай басхүү үр чадвар шаардсан акробат бүхий хэсгүүдтэй. Бас "Operation Condor". Киноны зураг авалтыг элсэн цөлд нэмэх 40 градусын халуунд авч байлаа. Тун ч хэцүү байж билээ. "Atom of God" киноны зураг авалт дээр үзүүлбэрийнхээ үеэр

...Холливудад ажилласан бүхий л туршлага маань хөгжилтэй, бас сэтгэл хөдөлгөм байсан. Би тэнд маш олон шинэ зүйлст суралцаж, миний дүү Брэтт Ратнер нар шиг гэр бүл, шинэ найз нөхдөө олсон...

үхэх дөхсөн удаа ч бий. Харин "Оргил цаг" кинонд ангиар ярих шаардлагатай болсон нь хамгийн хэцүү байв.

-Холливудын киноны арга барил хийгээд Хонконгийн кино юугаараа ялгаатай байдаг вэ?

-Холливудын кино бүтээх арга барил нь зохион байгуулалттай, маш системтэй байгааг би анзаарсан. Зохион байгуулалттай байна гэдэг мэдэж сайн хэрэг. Гэхдээ заримдаа надад хэт нэг дүрэм, журамд хүлэгдчихсэн юм шиг санагддаг. Харин Хонконг киног хийхэд зураг авалтын явцад үзэгдлийг өөрчилж болдог. Тэгэхээр илүү тэсрэлттэй, илүү динамик байж чаддаг гэж боддог. Бас ишүү уян хатан, бүтээлч.

Хэрвээ бидэнд ингэчихвэл зүгээр юм биш үү ч гэх юм уу арай өөр бодол орж ирвэл түүнийгээ шууд л туршиж үзэх боломжтой байдаг юм.

-Таны хувьд кино урлагийн салбарт гарсан хамгийн гайхалтай өөрчлөлт, шинэчлэлтийг юу гэж харж байна вэ?

-Кино урлагийн салбарт хөл тавьснаас хойш аль хэдийнэ 50 гаруй жилийн нүүрийг үзсэн байна. Энэ хугацаанд гарсан хамгийн гайхалтай өөрчлөлт нь кино уран бүтээл 35 мм-ын хальснаас, дижитал технологид шилжиж, 3D технологийн зураг авалтыг нэвтрүүлсэн явдал гэж боддог. Технологи сайжирснаар өнөөдрийн кинонууд бүтсэн хэрэг. Бидний өнгөрсөнд ашиглаж байсан тэр зүйлс одоо түүхийн нэг хэсэг болон үлдэж дээ. Би дижитал технологийг биширдэг. Үүний үр дүнд л зураг авалтын дараах CG компьютер эффектнийг хийх боломжтой болсон ишүү дээ.

-Холливудад хуримтуулсан туршлагаасаа хамгийн сонирхолтойг нь бидэнд сонирхуулаач?

-Холливудад ажилласан бүхий л туршлага маань хөгжилтэй, бас сэтгэл хөдөлгөм байсан. Би тэнд маш олон шинэ зүйлст суралцаж, миний дүү Брэтт Ратнер нар шиг гэр бүл, шинэ найз нөхдөө олсон. Холливуд надад гайхалтай дурсамж үлдээсэн. Магадгүй хамгийн хөгжилтэй нь "Оргил цаг" цуврал кино байсан байх.

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр -16
Шөнө -26

Нөгөөдөр
Өдөр -16
Шөнө -27

Өдрийн зурхай

ӨВЛИЙН ДУНД ИЛҮҮ ЦАГААН ХУЛГАНА САР ЕСӨН УЛААН МЭНГЭТЭЙ ШАР НОХОЙ ӨДӨР

Наран ургах шингэх: 08.39-17.21
Үс засуулбал: Эд мал арвидна



Тухайн өдөр гахай, хулгана, үхэр, луу, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба логой, морь жилтнээ сөрөг луу нөлөөтэй тул элдэв үйлд хяналтай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр насны хүч дэлгэрнэ. Эл найруулах, угаал үйлдэх, бэр авах, насны авшиг, насны бүтээл хийх зан үйл хийгээд торол садан боллоцох, худалдаа найтааны үйл, үсэг зурхайд суралцаж, бэрийн болон буяны үйл, дайсныг дарайх сайн. Зүүн нүд татвал үзэсгэлэн болох, баруун нүд татвал үйл өчүүхэн бүтэх, баруун чих хангинавал гоо болох, зүүн чих хангинавал сайн. Нохой уливал хааны хэрэг болох, хэрэг дуугарвал өөрийн цусыг үзэх, тагнай загатнавал гэрт үзэсгэлэн болох, бүх бие татвал эд алдах, хөлийн мах татвал сайн гэдэг. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой.

Бидэнд тохиолдсон



Dea Akana



Хэдэн өдрийн өмнө манай хүн хүнсээ цуглуулахдаа уксус авсан юм. Тэгээд хүүхдүүдээ уучихаж магадгүй гээд би "Энэ хор шүү, ууж амсаж болохгүй. Аюултай" гэж хэлээд өнгөрсөн юм. Харин өчигдөр


орой гэртээ очоод ханийнхаа хийсэн цуйван, салатыг амтархан идлээ. Гэтэл том хүү ээжийнхээ нүдийг хариулж байгаад над руу гялс гүйж ирснээ "Аав аа, ээж таныг хорлох гээд наадах руу чинь хор хийчихсэн."

Битгий идээрэй" л гэлээ. Би ч "Үгүй байлгүй дээ" гэж хэлээд салатнаасаа идчихсэн чинь хүү маань ээж рүүгээ уйлаад дайрчихсан. "Аавыг алчихлаа. Та хор хийчихсэн биз дээ, би авгүй болчихлоо" гээд л. Хэ хэ хэ


Мессигийн хөшөөг сүйтгэжээ

Хэсэг танхай хүмүүс Аргентины хөлбөмбөгчин Лионель Мессигийн хөшөөний дээд хэсгийг тасдан хаяжээ. Энэ тухай даваа гарагт Буэнос-Айрес хотын захиргаа мэдэгдсэн байна. "Ondacero" гэдэг радиостанц твиттер хуудсанд даа уг хөшөөний зургийг байрлуулжээ. Эвдэн сүйтгэгч хорон санаатнуудын энэ үйлдлийн улмаас хөшөөний суурин дээр зөвхөн Мессигийн хөл болон хөлбөмбөгийн бөмбөг л үлджээ. Хотын захиргаа хөшөөг сэргээн босгохоор ажиллаж байна. Мессигийн хөшөөг

Буэнос-Айрес хотын Пуэрто-Мадеро гэдэг баячуудын хороололд 2016 оны зургадугаар сарын сүүлээр босгосон юм. Тухайн үед Америкийн цомын гэмцээний финалын тоглолтод Месси торгуулийн цохилт алдсанаар Аргентины баг Чилийн шигшээд ялагдсан юм. Үүний дараа сэтгэлээр унасан Месси улсынхаа шигшээ багт дахин тоглохгүй гэж мэдэгдэж байв. Харин сар гаруйн дараа тэрбээр энэ шийдвэрээ өөрчилжээ.



Аз жаргал, зовлон гуниг, хайр дурлал, хардалт, амжилт, бүтэлгүйтэл гээд л хар, цагаан хосолж байдаг хүний амьдралд бид төрөхдөө "Амьдралын сурах бичиг"-ээ өвөртлөөд ирдэг бол хичнээн сайхан! Өөрийн биеэр туулж байж л амьдралын зах зухаас мэдэж, сурч, туршлагажиж ухаардаг. Энэ бол "Амьдралог" юм. Тэгвэл амьдралынхаа 2 дахь үеийн хямралд орсон гэр бүлийн хос, амжилттай яваа ч заяаны ханна хараахан олоогүй бүсгүй, залуу халуун насныхаа алдаа, оноог дэнслүүлэн яваа оюутан охин болон киноны бусад дүүргийн аз жаргалын төлөөх тэмцэл болон тэдний санаанд оромгүй сонголтуудыг "Амьдралог" романтик инээдмийн уран сайхны киноноос үзээрэй.



Assassin's Creed буюу Алуурчны үнэмшил видео тоглоомоос сэдэвлэн бүтээв.



Жаз хөгжимчин Сибастан жуужигчин болох хүсэл мөрөөдөлтэй Миа бүсгүйд дурлана. Миа киноны шалгаруулалтуудад орохын хажуугаар кино одуудад кофе зөөдөг бол жаз хөгжимчин Сибастан ядруухан баранд коктэйлийн үдэшлэгийн хөгжим тоглож амь зогоодог байв. Амжилтад ойртохын хэрээр тэд тэдний эмээгхэн хайрыг сэвтээх хүнд шийдвэрүүдийг гаргах хэрэгтэй болно.